

ХОВД АЙМАГ ЧАНДМАНЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 7/06

Урд гол

ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨР ХУРААМЖ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 7 дугаар хуралдаанаас **ТОГТООХ нь:**

1.Чандмань суманд мөрдөгдөх хог хаягдлын төлбөр, хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Хог хаягдлын төлбөр хураамжийн хэмжээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад таниулан хэрэгжүүлж, төлбөр, хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Чинбат) -д үүрэг болгосугай.

3.Тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн мэргэжилтэн (Н.Энхзул) -д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Дамба), ИТХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга, нийт гишүүдэд даалгасугай.

5.Уг тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын 2025 оны 12 сарын 18-ны өдрийн 06/05 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

ГАЛТАНСҮХ

*Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын
7 дугаар хуралдааны 2026 оны 03 дугаар сарын 31-ны
өдрийн 7/06 тоот тогтоолын хавсралт*

**ЧАНДМАНЬ СУМАНД МӨРДӨГДӨХ ХОГ ХАЯГДЛЫН
ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдлын төлбөр хураамж төлөх субъект	Төлбөр хураамжийн хэмжээ /сараар/
1	Засаг даргын тамгын газар	12000
2	Ерөнхий боловсролын сургууль	12000
3	Хүүхдийн цэцэрлэг	12000
4	Соёлын төв	12000
5	Эрүүл мэндийн төв	12000
6	Шатахуун түгээх станц	10000
7	Хүнсний дэлгүүр	10000
8	Цайны газар ,Зоогийн газар,гуанз	10000
9	Үсчин, гутал засвар	5000
10	Зочид буудал,караоке,баар	10000
11	Авто засвар,Дугуй засвар	5000
12	Биллиард,тоглоомын газар	5000
13	Талх нарийн боовны цех	5000
14	Банк санхүүгийн байгууллага	5000
15	Хувийн мал эмнэлэг	5000
16	Эмийн сан	5000
17	Айл өрх	1000
18	Нийтийн эзэмшил задгай талбайд худалдаа үйлчилгээ явуулсан ААН, иргэнд	20000
19	Нийтийн халуун ус	1000
20	Аялал жуулчлалын бааз	30000
21	Уурын зуух	100000

Тайлбар: Айл өрхийн хураамжийн хэмжээг дунджаар нэг өрхийг 4 гишүүнтэй гэж тооцоод 1 хүнд 250 төгрөгийн хураамж ноогдоно.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 5 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 10/01

Хархорин
сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

3.Уг тогтоол гарсантай холбогдуулан 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоол, 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 06/02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П.НЭНДАРАМ

**Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 5 дугаар сарын 22-ны
өдрийн 10/01 тоот тогтоолын хавсралт**

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгч	Хэмжих нэгж	Хураамжийн хэмжээ (төгрөг)
1	Өрх бүр	Сар бүр	5000
2	Сумын төв дээр малаа маллаж байгаа өрх	Сар бүр	10000
3	Зочид буудал, амралтын газар, жуулчны бааз	Сар бүр	48000
4	Хүүхдийн цэцэрлэг, ясли	Сар бүр	19000
5	Ерөнхий боловсролын сургууль 500 хүүхдээс дээш	Сар бүр	110000
6	Ерөнхий боловсролын сургууль 500 хүүхдээс доош	Сар бүр	55000
7	Шинжлэх ухаан, судалгааны байгууллага	Сар бүр	7000
8	Соёлын төв	Сар бүр	22000
9	Спортын ордон	Сар бүр	30000
10	Төрийн болон төрийн өмчит байгууллага	Сар бүр	11000
11	Сүм, хийд	Сар бүр	22000
12	Эмийн сан, тусгай зөвшөөрөлтэй дэлгүүр супер маркет	Сар бүр	23000
13	Тусгай зөвшөөрөлгүй дэлгүүр (ашигтай талбай хэмжээ 50 м2-аас бага)	Сар бүр	5000
14	Зах худалдааны төв	Сар бүр	100000
15	Эмийн сан	Сар бүр	7000
16	Авто засвар, дугуй засвар	Сар бүр	3000
17	Шатахуун түгээх станц	Сар бүр	30000
18	Түүхий эдийн худалдаа	Сар бүр	10000
19	Ресторан, бар, кафе	Сар бүр	13000
20	Үүрэн телефон холбоо	Сар бүр	3000
21	Банк, санхүүгийн байгууллага	Сар бүр	4000
22	Авто тээврийн товчоо, нисэх онгоцны буудал	Сар бүр	7000
23	"Хөдөө аж ахуйн корпорац" ТӨХХК-ийн Хархорин салбар	Сар бүр	25000
24	Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ны Хархорин сум дахь салбар	Сар бүр	8500
25	Эрүүл мэндийн байгууллага	Нэгдсэн эмнэлэг	Сар бүр 100000
		ӨЭМТөв"Энэрэл Хархорин"	Сар бүр 12000
		Үүдэн эмнэлэг	Сар бүр 3000
26	Үйлдвэрлэл эрхлэгч	Газар тариалан	Сар бүр 8500
		Мах боловсруулах	Сар бүр 30000
	Тайлбар: Өрхийг дунджаар 4 гишүүнтэй, 1 хүнд 1250 төгрөг ногдохоор тооцоолж 1 өрхийн 5000 төгрөг байхаар тооцоолов.		

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН “ЧАНДМАНЬ НАЛАЙХ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Налайх дүүргийн “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг нэгдүгээр, суурь хураамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Чандмань Налайх” ОНӨААТҮГ /Б.Батбилэг/-т үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Чандмань Налайх” ОНӨААТҮГ /Б.Батбилэг/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2021 оны 75 дугаар тогтоол, Зохицуулах хорооны 2026 оны 57 дугаар тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА
ГИШҮҮН

Г.ЦОГТСАЙХАН
Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 6 дугаар сарын 26-ны
өдрийн 83 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

**НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН “ЧАНДМАНЬ НАЛАЙХ”
ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

**Нэг. Айл өрх
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Тоолууртай	төг/л	2.00
	Тоолуургүй	төг/л	2.97
	Ус түгээх байр	төг/л	3.63
Бохир ус	Тоолууртай	төг/л	1.82
	Тоолуургүй	төг/л	2.65

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(НӨАТ-гүй)**

Ангилал		Хэмжих нэгж	Тариф
Цэвэр ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	3.50
	Төсөвт байгууллага	төг/л	4.40
	Спирт, архи, пиво, ундаа жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	4.94
Бохир ус	Дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	3.20
	Төсөвт байгууллага	төг/л	4.40
	Спирт, архи, пиво, ундаа жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/л	4.94
	Зөвөрөөр	төг/л	10.0

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 6 дугаар сарын 26-ны
өдрийн 83 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН “ЧАНДМАНЬ НАЛАЙХ”
ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ
ХУРААМЖ**

**Нэг. Хүн ам
(НӨАТ-гүй)**

Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Цэвэр	Бохир
Айл өрх	төг/сар	3.125	625

**Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага
(төгрөг/сар, НӨАТ-гүй)**

№	Оролтын шугамын голч (мм)	Цэвэр ус	Бохир ус
1.	15	6,600	1,500
2.	20	9,000	1,800
3.	25	13,800	2,700
4.	32	20,520	4,050
5.	40	30,600	6,000
6.	5	48,120	9,600
7.	65	59,760	11,850
8.	80	79,080	15,750
9.	100	114,600	22,920
10.	125	139,800	27,600
11.	150	189,720	37,800
12.	200	234,000	46,800
13.	250	322,560	64,500
14.	300	426,600	85,200
15.	400=<	576,000	115,200

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар А/58

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нотариатын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 221/ШШ/2026/0003 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/06 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нотариатчийн мэргэшлийн хорооны ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.8¹, 4.8², 4.8³ дахь хэсэг нэмсүгэй:

“4.8¹. Нотариатын тойрог шилжих мэргэшлийн шалгалт нь бодлого бодох хэлбэртэй байна.

4.8². Шалгалтаар авбал зохих нийт онооны 60 ба түүнээс дээш оноо авсан бол шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

4.8³. Бодлогын шалгалтад энэ журмын 4.5.1, 4.5.4, 4.5.6, 4.5.7, 4.5.10, 4.6, 4.7, 4.8, 4.10, 4.11, 4.12, 4.13 дахь хэсэгт заасныг баримтална.”

2. Мөн журмын дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох мэргэшлийн шалгалтын товыг шалгалт эхлэхээс хуанлийн 45-аас доошгүй хоногийн өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Монголын Нотариатчдын Танхимын цахим хуудсаар дамжуулан нийтэд, нотариатын тойрог шилжих мэргэшлийн шалгалтыг шалгалт эхлэхээс хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө Танхимаар дамжуулан нотариатчдад мэдээлнэ.”

2/ 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг:

“3.5. Мэргэшлийн шалгалтын товыг олон нийтэд зарласан өдрөөс хойш ажлын 7 хоногт багтаан бүртгэлийг эхлүүлэх бөгөөд нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох мэргэшлийн шалгалтын бүртгэлийн үргэлжлэх хугацаа хуанлийн 30 хоног, тойрог шилжих мэргэшлийн шалгалтын бүртгэлийн үргэлжлэх хугацаа хуанлийн 10 хоног байна. Хугацаа хэтрүүлж ирүүлсэн хүсэлтийг бүртгэхгүй.”

3/ 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг:

“4.1.Мэргэшлийн шалгалт нь нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нотариатын тойрог шилжих гэсэн хоёр хэлбэртэй байна. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох мэргэшлийн шалгалтыг дараах журмын дагуу авна.”

3.Мөн журмын 4.14, 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямбад даалгасугай.

САЙД

С.АМАРСАЙХАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/67, А/201

Улаанбаатар
хот

ТУШААЛ, ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-д доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/2.4, 2.5 дахь хэсэг:

“2.4.Сэтгэцийн өвчин нь сэдэрсэн, гэмт хэргийн нөхцөлөөс шалтгаалан ухамсарт ухаан балартсаны улмаас нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй мөн шинжлүүлэгч ухаангүй тохиолдолд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг хойшлуулж болно.

2.5.Бага насны (0-3 нас) хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтооход эмчийн үзлэг, лабораторийн болон багажийн шинжилгээ, эцэг эх, асран хамгаалагчийн өгүүлэмж, сэтгэл зүйч, шинжээч нарын ажиглалт зэргийг үндэслэнэ.”

2/4.1¹ дэх хэсэг:

“4.1¹.Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг шүүх шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу хийнэ.”

2.Мөн журмын 1.4 дэх хэсгийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” гэсний дараа “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” гэж нэмсүгэй.

3.Мөн журмын дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2.1, 2.2 дахь хэсэг:

“2.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох шинжилгээг эрх бүхий этгээдийн шийдвэрээр сэтгэцийн эмч, сэтгэл зүйч /цаашид “шинжээч” гэх/ багаар болон дангаар хийнэ.

2.2.Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн дараах гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох шинжилгээг шинжээч дангаар хийж болно.”

2/3.4 дэх хэсэг:

“3.4.Шинжээч нь мэргэжлийн ёс зүй, байгууллагын дотоод журмыг баримтлан ажиллаж, эмнэлгийн мэргэжилтний хувьд мэргэжлийн чадвараа тасралтгүй хөгжүүлж, холбогдох сургалтад тогтмол хамрагдана.”

3/4.3 дахь хэсэг:

“4.3.Шинжилгээ хийх аргачлалын асуумж, сорил, үр дүнг боловсруулах арга зүй, хэрэглэгдэх материал нь шинжээчийн хяналтад хадгалагдах бөгөөд 2 жил тутамд шинэчилж болно.

4/5.4 дэх хэсэг:

“5.4.Хохирогчид илэрсэн эмгэг өөрчлөлт, багажийн болон лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн баримт бичиг, бусад материалыг нэгтгэн үнэлж үзсэний үндсэн дээр шинжээч гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд сэтгэцийн шинжээч эмч сэтгэцийн өвчний олон улсын ангиллын дагуу онош тавина.”

4.Журмын 2 дахь хэсгийн “2.1.1-2.1.5” гэснийг “2.2.1-2.2.5”, “2.6” дахь хэсгийг “2.3” гэж, 2.3 дахь хэсгийн “Шаардлагатай тохиолдолд” гэснийг “Эрх бүхий этгээд” гэж, 3.3 дахь хэсгийн “2.7” гэснийг “4.1” гэж, 4.2 дахь хэсгийн “зүйг” гэснийг “зүй” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Журмын 3.2 дахь хэсгийн “клиник” гэснийг, 3.4 дэх хэсгийн “эмгэг сэтгэц судлалын болон шүүхийн сэтгэц судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байна” гэснийг, 4.2 дахь хэсгийн “нууцлах бөгөөд энэхүү нууцлал нь” гэснийг, 4.3 дахь хэсгийн “нууцлалтайгаар” гэснийг, 5.1 дэх хэсгийн “болон” гэснийг тус тус хассугай.

6.Журмын 2.3, 2.4, 2.5, 2.7, 2.8, 2.9, 2.10 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцугай.

8.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбямба), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Эрдэнэбаяр) нарт тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

С.АМАРСАЙХАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Э.БАТШУГАР